



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 05 өдөр

Дугаар 4/332

Мандалговь

Урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 05 дугаар “Журам батлах тухай” тогтоолын 1 дүгээр хавсралт “Төрийн албан хаагчдад шагнал олгох журам”-ын 3 дугаар хэсгийн 3.3, 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 222 дугаар “Зарим аймгийн баяр наадмын хугацааг өөрчлөн тогтоох тухай” тогтоол, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар хэсгийн 2.1.6 дахь заалт, Аймгийн засаг даргын зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 11 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойн баярын үйл ажиллагааг зохион байгуулахад идэвх санаачилгатай, шинэ санал санаачилга гаргаж ажилласан 125 төрийн албан хаагчдад нэг сар хүртэлх үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн шагнал олгосугай.

2. Шагнагдах албан хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Шагналд шаардагдах 41,851,805 (Дөчин нэгэн сая найман зуун тавин нэгэн мянга найман зуун таван) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс, 25,063,275 (Хорин таван сая жаран гурван мянга хоёр зуун далан таван) төгрөгийг нэмэлт санхүүжилтээс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат)-д, 26,831,113 (Хорин зургаан сая найман зуун гучин нэгэн мянга нэг зуун арван гурван) төгрөгийг “Хот тохижуулах газар”-ын төсвөөс зарцуулах эрхийг “Хот тохижуулах газар”-ын дарга (Д.Очбадрах), Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111131